



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 61573

Улаанбаатар хот

Н.Энхтуяад сахилгын  
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.4, 10.6, 10.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч Нэргүйн Энхтуяа нь хуулиар хүлээсэн албан үүрэгтээ хариуцлагагүй хандаж, улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчиж, эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэсэн нь Хяналтын улсын байцаагчийн 2023 оны 3744 дугаартай дүгнэлт, Хяналт шалгалтын газрын 2023 оны 66 дугаартай дотоод албан бичиг, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Н.Энхтуяад үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Б.Төгс-Эрдэнэ/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142303681